

**ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023 оны эхний 7 сарын байдлаар

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Эрчим хүчний сэргэлтийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг мэдээллээр хангахад оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Төсөл, арга хэмжээнүүдийн 2023 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалыг баримтлав.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан эрчим хүчний сэргэлтийн чиглэлээрх 5 бодлогын зорилтын хүрээнд 13 үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Зорилтын үнэлгээ

Зорилт	Үйл ажиллагааны тоо	Биелэлтийн дундаж	Зорилтын Үнэлгээ
Зорилт 2.1.Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ.	7	55.7%	Эрчимжүүлэх шаардлагатай
Зорилт 2.2.Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангана.	3	70%	Тодорхой үр дүнд хүрсэн
Зорилт 2.3.Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ.	1	70%	Тодорхой үр дүнд хүрсэн
Зорилт 2.4. Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, сүлжээнд холбогдох хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын бэлтгэл ажлыг хангана.	1	70%	Тодорхой үр дүнд хүрсэн
Зорилт 2.5.Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолой барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.	1	70%	Тодорхой үр дүнд хүрсэн

Төсөл, арга хэмжээний үнэлгээ

№	Зорилт	Үйл ажиллагаа	Хэрэгжилт
1	Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ.	Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц, 220 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, өмнөд бүсийн стратегийн орд газрууд болон үйлдвэрлэл, технологийн паркуудын эрчим хүчний хэрэглээг хангах	30%
2		Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөж, зүүн бүсийн уул уурхай, аялал жуулчлалын төслүүдийн эрчим хүчний хэрэглээг хангах	70%
3		Амгалангийн дулааны станцыг өргөтгөн Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны хэрэглээний өсөлтийг хангах	50%
4		Дулааны III цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн 400 МВт-ын хүчин чадалтай шинэ эх үүсвэр барих	30%
5		Багахангайн 300 МВт-ын цахилгаан станцыг барьж, нийслэл Улаанбаатар хотод хийгдэх шинэ эко, ногоон бүтээн байгуулалтын төслүүдийн эрчим хүчний хэрэглээг хангах	70%
6		Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барьж Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчийг бүс нутгийн сүлжээнд нийлүүлэх	50%
7		Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ дагуул хотууд болон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэхэд шаардлагатай дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэх	90%
8	Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангана.	Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барьж баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах	50%
9		Төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд 160 МВт.ц багтаамжтай цэнэг хуримтлуурыг ашиглан нэгдсэн сүлжээний оргил ачааллыг тохируулах боломжийг бүрдүүлэх	70%
10		Эгийн голын усан цахилгаан станцын биологийн олон янз байдлын нөлөөллийн судалгааг дуусгаж, Дэлхийн өвийн хороонд хүргүүлэх	90%
11	Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ.	Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлж улирал тутам шинэчилнэ.	70%
12	Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, сүлжээнд холбогдох хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын бэлтгэл ажлыг хангана.	Өмнийн говийн нар салхины эх үүсгэврийг ашиглаж сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэн Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх судалгаа хийх	70%
13	Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолой барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.	Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангах	70%
Дундаж			62.3%

Хэрэгжилт 70-90 хувьтай, тодорхой үр дүн гарсан 8 арга хэмжээ:

- Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөж, зүүн бүсийн уул уурхай, аялал жуулчлалын төслүүдийн эрчим хүчний хэрэглээг хангах;
- Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ дагуул хотууд болон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэхэд шаардлагатай дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэх;
- Төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд 160 МВт.ц багтаамжтай цэнэг хуримтлуурыг ашиглан нэгдсэн сүлжээний оргил ачааллыг тохируулах боломжийг бүрдүүлэх;
- Багахангайн 300 МВт-ын цахилгаан станцыг барьж, нийслэл Улаанбаатар хотод хийгдэх шинэ эко, ногоон бүтээн байгуулалтын төслүүдийн эрчим хүчний хэрэглээг хангах
- Эгийн голын усан цахилгаан станцын биологийн олон янз байдлын нөлөөллийн судалгааг дуусгаж, Дэлхийн өвийн хороонд хүргүүлэх;
- Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлж улирал тутам шинэчэх;
- Өмнийн говийн нар салхины эх үүсгэврийг ашиглаж сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэн Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх судалгаа хийх;
- Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангах.

Хэрэгжилт 30-50 хувьтай, эрчимжүүлэх шаардлагатай 5 арга хэмжээ:

- Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц, 220 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, өмнөд бүсийн стратегийн орд газрууд болон үйлдвэрлэл, технологийн паркуудын эрчим хүчний хэрэглээг хангах;
- Дулааны III цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн 400 МВт-ын хүчин чадалтай шинэ эх үүсвэр барих;
- Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барьж баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах;
- Амгалангийн дулааны станцыг өргөтгөн Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны хэрэглээний өсөлтийг хангах;
- Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барьж Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчийг бүс нутгийн сүлжээнд нийлүүлэх.

Гурав. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д Эрчим хүчний сэргэлтийн чиглэлээр 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 13 үйл ажиллагааны 2023 оны эхний 7 сарын байдлаарх хэрэгжилтийн явц 62.3 хувьтай байна. Үүнээс **тодорхой үр дүнд хүрсэн, 70-90 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай, удаашралтай, 30-50 хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ** тус тус байна.
2. Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд тусгагдсан 5 зорилтоос 1 буюу Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх 2.1 дэх зорилт “*эрчимжүүлэх шаардлагатай*” гэж үнэлэгдсэн бол бусад 4 зорилт “*тодорхой үр дүнд хүрсэн*” гэж үнэлэгдэв.
3. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх эрчим хүчний 21 төслийн хэрэгжилт 51.4 хувьтай байна.

4. Шинэ сэргэлтийн бодлогын эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд дэх үйл ажиллагааны хэрэгжилт удаашралтай байгаад анхаарч хэрэгжилтийг эрчимжүүлэх, бодлогын зорилтын хүрээнд төлөвлөгдсөн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэлийн төсөл арга хэмжээ, үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжилтийг эрчимжүүлж, жилийн эцэст хэрэгжилтийн түвшинг ахиулж, үр дүн гаргаж ажиллах шаардлагатай.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн дэлгэрэнгүй хэрэгжилтийг хавсаргав.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2023-08-02